



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/166

Булган

Ажлын хэсэг байгуулах тухай

Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 10 дугаар зүйлийн 10.1.6, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 06 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөцийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өсвөрийн Жудо бөхийн бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг аймгийн хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: - Аймгийн Засаг даргын орлогч Ц.Бат-Өлзий

- Гишүүд:
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Д.Эрдэнэбилэг
 - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны дарга О.Ундрах
 - Боловсрол, соёл урлагийн газрын дарга Э.Түвшинмөнх
 - Биеийн тамир, спортын газрын дарга А.Ханддорж
 - Хөгжимт жүжгийн театрын дарга Т.Бэхтөр
 - Аймгийн Цагдаагийн газрын Нийтийн хэв журмын ажил хариуцсан ахлах байцаагч, хошууч Д.Мягмаржав
 - Биеийн тамир, спортын газрын албаны дарга Л.Ганболд

Нарийн бичгийн дарга: - НБХ-ийн мэргэжилтэн Ж.Халиунаа

2. Бүсийн аварга шалгаруулах тэмцээнд шаардагдах 6 758 500 /зургаан сая долоон зуун тавин найман мянга таван зуу/ төгрөгийг хавсралтаар баталж, Засаг даргын нөөцийн хөрөнгөөс гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Д.Батцогт/-т зөвшөөрсүгэй.

3. Өсвөрийн Жудо бөхийн бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг амжилттай зохион байгуулж ажиллахыг ажлын хэсэг /Ц.Бат-Өлзий/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  З.БАТЗОРИГ

20190196